

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын /цаашид “Журам” гэх/ зорилго нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК /цаашид “Бирж” гэх/ хүсэлт гаргасан этгээдийг Биржийн гишүүнээр элсүүлэх, түүнд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасан эрхийг олгох, түүнтэй холбоотой үйл ажиллагааг тодорхойлж, зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журам нь Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль /цаашид “Биржийн тухай хууль” гэх/, Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам /цаашид “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” гэх/ болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмын хүрээнд мөрдөгдөнө.
- 1.3. Энэ журмын нэмэлт өөрчлөлт болон хүчин төгөлдөр мөрдөгдөх хугацааг Биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- 1.4. Бирж болон түүний гишүүний хооронд үүсэх гишүүнчлэлтэй холбоотой харилцааг зохицуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх бүхий алба нь Биржийн Гишүүнчлэлийн алба байна.
- 1.5. Гүйцэтгэх удирдлага өөрөөр шийдвэрлээгүй бол энэ журам, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрөөс хуанлийн 7 хоногийн өмнө нийтэд мэдэгдэнэ.

Хоёр. Гишүүнчлэлийн төрөл

- 2.1. “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 4.5-д заасны дагуу Биржийн гишүүнчлэлийг байнгын болон байнгын бус гэсэн үндсэн 2 төрлөөр олгоно.
- 2.2. Байнгын гишүүн гэж “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 4.5.1-т заасан хуулийн этгээдийг ойлгох ба харилцагчийн данс нээх, захиалга шивэх, худалдах, худалдан авах гэрээ байгуулах үйл ажиллагаа явуулна.
- 2.3. Байнгын гишүүн нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д заасан дараах эрхийг бүхэлд нь болон хэсэгчлэн эдэлнэ. Үүнд:
 - 2.3.1. Гишүүнчлэлийн;
 - 2.3.2. Арилжааны;
 - 2.3.3. Клирингийн;
 - 2.3.4. Зах зээл үүсгэх.
- 2.4. Байнгын бус гишүүн гэж “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 4.5.2-т заасан хуулийн этгээдийг ойлгох ба захиалга шивэх, худалдах, худалдан авах гэрээ байгуулах үйл ажиллагаа явуулна.
- 2.5. Байнгын бус гишүүн “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д заасан арилжааны эрхийг эдэлнэ.

Гурав. Гишүүнээр элсүүлэх

- 3.1. Биржийн гишүүнээр элсэхээр хүсэлт гаргагч нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 4.2-т заасан Биржийн гишүүний шалгуур үзүүлэлтэд заасан бичиг баримтын бүрдлийг Гишүүнчлэлийн албанд ирүүлнэ.
- 3.2. Гишүүнчлэлийн алба гишүүний шалгуур үзүүлэлтэд заасан бичиг баримтын бүрдэлд үндэслэн ажлын 5 өдрийн дотор анхан шатны дүгнэлт /Хавсралт 1/ гаргана.

- 3.3. Биржийн гишүүний шалгуур үзүүлэлтэд заасан шаардлагыг хангасан тухай бичиг баримтын бүрдлийг Гишүүнчлэлийн албанд хүлээлгэн өгнө. Бичиг баримтыг бүрэн хүлээн авч, баталгаажуулсан өдрийг “бичиг баримт хүлээн авсан өдөр” гэж тооцно.
- 3.4. Бичиг баримт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Бирж дараах шийдвэр гаргана. Үүнд:
 - 3.4.1. Хүсэлт гаргагчийн бичиг баримт буцаах тухай;
 - 3.4.2. Гишүүнчлэлийн гэрээ байгуулах тухай;
 - 3.4.3. Гишүүнчлэлийн гэрээ байгуулахаас татгалзсан тухай.
- 3.5. Хүсэлт гаргагчийн бичиг баримтыг буцаах тухай шийдвэрийг дараах тохиолдолд Гишүүнчлэлийн алба гаргана. Үүнд:
 - 3.5.1. Бичиг баримтын бүрдэл хуурамч, хүчин төгөлдөр бус, буруу мэдээлэл агуулсан;
 - 3.5.2. Хүсэлт гаргагчийн зүгээс бичиг баримтыг эргүүлэн татах хүсэлт гаргасан.
- 3.6. Хүсэлт гаргагч нь энэ журмын 3.4.1-т заасан шийдвэрийн талаар Хяналт, мониторингийн албанд ажлын 5 өдрийн дотор гомдол гаргах эрхтэй. Гомдлыг “Хяналт, мониторингийн албаны журам”-д заасны дагуу шийдвэрлэнэ.
- 3.7. Журмын 3.4.2, 3.4.3-т заасан шийдвэрийг Биржийн гүйцэтгэх удирдлага гаргах бөгөөд энэхүү шийдвэр нь эцсийн байна.
- 3.8. Журмын 3.4.2-т заасан шийдвэр гарсан тохиолдолд хүсэлт гаргагчтай Биржийн гишүүнчлэлийн гэрээг /Хавсралт 2/ 1-3 жилийн хугацаатай байгуулна.
- 3.9. Журмын 3.3-т зааснаар “бичиг баримт хүлээн авсан өдөр” нь Биржийн гишүүний шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасанд тооцогдохгүй бөгөөд бирж хүсэлт гаргагчтай гишүүний гэрээг байгуулах үндэслэл болохгүй.

Дөрөв. Гишүүний үйл ажиллагаа

- 4.1. “Биржийн тухай хууль”-ийн 10.2-т заасны дагуу Биржийн байнгын гишүүн нь үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байна.
- 4.2. Байнгын гишүүн нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д заасны дагуу дараах эрхийг бүхэлд нь болон хэсэгчлэн эдэлнэ. Үүнд:
 - 4.2.1. **Гишүүнчлэлийн эрх** гэж харилцагчийн данс нээх эрхийг ойлгох бөгөөд Биржтэй байгуулсан гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд гишүүнчлэлийн эрхийг эдэлнэ. Гишүүнчлэлийн эрхтэй байнгын гишүүн нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - i. Байнгын гишүүн харилцагчтай зуучлалын гэрээ байгуулж, харилцагчид арилжааны данс нээнэ.
 - ii. Байнгын гишүүн данс нээхтэй холбоотой харилцагчийн мэдээллийг Биржийн програм¹-д үнэн зөвөөр бүртгэнэ.
 - 4.2.2. **Арилжааны эрх** гэж Биржийн арилжаанд өөрийн болон харилцагчийн нэрийн өмнөөс захиалга оруулах, худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг ойлгох бөгөөд байнгын гишүүн нь Биржээс түдгэлзүүлээгүй тохиолдолд Биржтэй байгуулсан гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд арилжааны эрх эдэлнэ. Арилжааны эрхтэй байнгын гишүүн дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
 - i. Байнгын гишүүн өөрийн харилцагчтай зуучлалын гэрээ байгуулна.
 - ii. Харилцагчийн захиалгыг зуучлалын гэрээний дагуу захиалгын маягтыг үндэслэн арилжаанд оруулна.
 - iii. Байнгын гишүүн харилцагчийн хэлцлийн жагсаалтыг захиалгатай тулгаж, худалдах, худалдан авах гэрээг харилцагчийн олгосон итгэмжлэлийн хүрээнд байгуулж болно.

¹ Биржээс суурилуулсан Брокерын компанийн програм хангамж

- iv. Байнгын гишүүн нь холбогдох хууль, журмын дагуу худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 4.2.3. **Клирингийн эрх** гэж харилцагчийн нэрийн өмнөөс “Клиринг, төлбөр тооцооны журам”-д заасны дагуу дэнчин, барьцаа байршуулах, худалдах, худалдан авах гэрээний төлбөр тооцоо гүйцэтгэх эрхийг ойлгох бөгөөд клирингийн эрхтэй байнгын гишүүн дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
- i. “Клиринг, төлбөр тооцооны журам”-ын дагуу барьцаа хөрөнгө байршуулна.
 - ii. Худалдах, худалдан авах гэрээний төлбөр, тооцооны хэрэгжилтийг хангаж ажиллана.
 - iii. Өөрийн болон харилцагчийн дэнчин, төлбөр тооцооны гүйлгээг биржийн програмд үнэн зөв оруулна, бүртгэнэ.
 - iv. Харилцагчийн хэлцэлд харгалзах худалдах, худалдан авах гэрээний төлбөрийг Биржээс баталсан хүлээлцэх баримтыг үндэслэн гүйцэтгэнэ.
 - v. Харилцагчийн хэлцэлд харгалзах худалдах, худалдан авах гэрээний төлбөрийг гүйцэтгэхдээ арилжаа, төлбөр тооцоотой холбоотой аливаа шимтгэл хураамж, бусад хүү төлбөрийг суутгаж болно.
- 4.2.4. **Зах зээл үүсгэх эрх** гэж Биржийн арилжаанд зах зээл үүсгэх захиалга оруулах эрхийг ойлгох бөгөөд зах зээл үүсгэх эрхтэй байнгын гишүүн өөрийн нэрийн өмнөөс бараа, түүхий эдэд суурилсан гэрээний авах болон зарах захиалгыг зэрэг оруулах боломжтой. Зах зээл үүсгэх захиалгыг Биржээс тогтоосон нөхцөлийн дагуу оруулна.
- 4.3. Байнгын бус гишүүн нь Биржтэй гишүүнчлэлийн гэрээ байгуулснаар арилжаанд өөрийн нэрийн өмнөөс авах эсвэл зарах захиалга оруулна.
- 4.4. Биржийн гишүүн гишүүнчлэлийн гэрээнд заасан эрхийн хүрээнд Биржээс зөвшөөрсөн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой шимтгэл, хураамжийг нэхэмжилсэн хугацаанд төлж барагдуулна.
- 4.5. Биржийн гишүүн шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхээс хамаарч Бирж энэхүү журмын 4.2.1-4.2.4-т заасан эрхийг олгож эсвэл сунгаж болно.
- 4.6. Журмын 4.2.1-4.2.4-т заасан эрхэд хамаатай шалгуур үзүүлэлтийг хангасан, үл хангасан гишүүний хүсэлтээр гишүүний эрхэд өөрчлөлт оруулж болно.
- 4.7. Журмын 5.1-т заасан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын дүгнэлтийн дагуу гишүүний эрхийг өөрчилж болно.
- 4.8. Биржийн гишүүнчлэлийн гэрээг сунгах хүсэлтэй гишүүн тухайн эрхэд хамаатай шалгуур үзүүлэлтийн гэрээний сунгалтын бүрдүүлэх бичиг баримтын бүрдлийг гишүүний гэрээ дуусгавар болох өдрөөс ажлын 15 өдрийн өмнө Гишүүнчлэлийн албанд ирүүлсэн байна.

Тав. Хяналт, шалгалт

- 5.1. Биржийн гишүүний мэдээллийг шинэчлэн бүртгэх, гишүүнд холбогдох шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж буй эсэхэд хяналт тавих зорилгоор Гишүүнчлэлийн алба Биржийн бусад алба болон холбогдох байгууллагуудтай хамтарсан шалгалтыг явуулна.
- 5.2. Гишүүнчлэлийн алба байнгын болон байнгын бус гишүүнд тавих хяналт, шалгалтын үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.2.1. Төлөвлөгөөт шалгалт
 - 5.2.2. Төлөвлөгөөт бус шалгалт
- 5.3. Биржийн зүгээс гишүүний шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж буй эсэх талаар төлөвлөгөөт шалгалтыг жилд 1 удаа зохион байгуулна. Төлөвлөгөөт бус шалгалтыг Биржийн санаачлагаар, эсвэл гуравдагч этгээдийн санал, гомдлыг үндэслэн зохион байгуулж болно.
- 5.4. Энэхүү журмын 5.2.1, 5.2.2-т заасан хяналт, шалгалтын үйл ажиллагааг Биржийн гүйцэтгэх удирдлагын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулна. Удирдамжийг

хууль, журамд заасан эрхийн хүрээнд боловсруулах ба дараах мэдээллийг заавал тусгана. Үүнд:

- 5.4.1. Шалгалтын агуулга, зорилго
- 5.4.2. Шалгалтын хамрах хугацаа
- 5.4.3. Шалгалтын бүрэлдэхүүн
- 5.4.4. Шалгалтын хамрах хүрээ
- 5.5. Төлөвлөгөөт шалгалтын удирдамжийг Биржийн гишүүнд шалгалт явуулахаас ажлын 5 өдрийн өмнө, төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийг тухайн удирдамж батлагдсан өдөр мэдэгдэнэ.
- 5.6. Биржийн гишүүн шалгалтын удирдамжтай бүрэн танилцах эрхтэй ба шалгалтын бүрэлдэхүүнийг ажлын байр, ажиллах нөхцөлөөр хангана.
- 5.7. Биржийн гишүүн хуулиар хамгаалагдсанаас бусад мэдээллийг шалгалтын бүрэлдэхүүнд гаргаж өгөх үүрэгтэй.
- 5.8. Шалгалтын бүрэлдэхүүн дүгнэлт, цаашид авах арга хэмжээний тухай тайланг шалгалт явуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор Биржийн гишүүнд танилцуулж баталгаажуулна.
- 5.9. Зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчлөөс хамаарч шалгалтын бүрэлдэхүүн зөрчил арилгах хугацаат үүрэг даалгаврыг Биржийн гишүүнд өгнө.
- 5.10. Биржийн гишүүн шалгалтын тайланд заасан хугацаанд зөрчлийг арилгаж, энэ тухай Биржид албан бичгээр мэдэгдэнэ.
- 5.11. Шаардлагатай тохиолдолд шалгалтын бүрэлдэхүүн зөрчил арилсан эсэхийг баталгаажуулах зорилгоор газар дээрх шалгалтыг зохион байгуулж болно.

Зургаа. Мэдээлэл солилцох

- 6.1. Гишүүний гэрээнд бүртгэгдсэн хаяг, утас, цахим шуудан болон биржийн програмыг Биржтэй мэдээлэл солилцох суваг гэж ойлгоно.
- 6.2. Энэхүү журмын 6.1-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон бол энэ тухай Биржид ажлын 1 өдрийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.
- 6.3. Биржийн үйл ажиллагаатай холбоотой, нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн мэдээ, мэдээллийг гишүүнд түгээх ажиллагааг Гишүүнчлэлийн алба гүйцэтгэнэ.
- 6.4. Биржийн цахим хуудаст байршуулсан мэдээ, мэдээлэл, дүрэм, журам болон холбогдох бичиг баримтыг Биржийн албан ёсны эх сурвалж гэж үзнэ.

Долоо. Гишүүний гэрээг дуусгавар болгох

- 7.1. Биржийн гишүүнчлэлийн гэрээг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно. Үүнд:
 - 7.1.1. Энэ журмын 4.8-д заасны дагуу гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй;
 - 7.1.2. Гэрээний хугацаа дуусгавар болсон;
 - 7.1.3. Гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай гүйцэтгэх удирдлагын шийдвэр гарсан;
 - 7.1.4. Гэрээнд заасан бусад.
- 7.2. Биржийн гишүүнчлэлийн гэрээ дуусгавар болсон тухай мэдээллийг гэрээ дуусгавар болсон өдөрт багтаан Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдэгдэнэ.

Найм. Зөрчил, хариуцлага

- 8.1. Биржийн гишүүн энэ журам болон гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хууль, журмаар олгосон эрхийн хүрээнд Бирж дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:
 - 8.1.1. Сануулах;
 - 8.1.2. Журмын 4.2, 4.3-т заасан эрхийг хэсэгчлэн болон дангаар түдгэлзүүлэх;
 - 8.1.3. Гишүүнчлэлийн гэрээг Биржийн санаачлагаар цуцлах.
- 8.2. Биржийн гишүүн гишүүнчлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, “Гишүүнчлэлийн журам”-ын 4.2.1-4.2.4-т заасан эрхийн хүрээнд Биржээс зөвшөөрсөн

үйл ажиллагааг холбогдох журмын дагуу гүйцэтгээгүй тохиолдолд Журмын 8.1.1-т заасны дагуу албан бичгээр сануулах, зөрчлийг заасан хугацаанд арилгах даалгавар өгөх, шаардлагатай тохиолдолд биржийн цахим хуудсаар мэдээлэх байдлаар хариуцлага тооцно.

- 8.3. Гишүүн 8.2-т заасан хугацаанд зөрчлийг арилгаагүй, байнгын гишүүний харилцагчийн санал гомдлыг үндэслэн төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын үйл ажиллагаа зохион байгуулахад Зуучлалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй зөрчил илэрсэн тохиолдолд Журмын 8.1.2-т заасан хариуцлага тооцно. Эрх түдгэлзүүлэх хугацааг Биржийн гүйцэтгэх удирдлага тогтооно.
- 8.4. Гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд гишүүний үйл ажиллагаанд Журмын 8.3-т заасан зөрчил дахин илэрсэн тохиолдолд Журмын 8.1.3-т заасан хариуцлагыг тооцох үндэслэл болно.

БАЙНГЫН ГИШҮҮНИЙ АНХАН ШАТНЫ ДҮГНЭЛТ

Огноо:

Хүсэлт гаргагчийн Биржийн шалгуур үзүүлэлтэд заасан баримт бичгийн бүрдэлд үндэслэн Гүйцэтгэх удирдлагын удирдамжийн дагуу хүсэлт гаргагчийн ажлын байр, хамтран ажиллах гэрээ байгуулсан итгэмжлэгдсэн агуулах, програм хангамж болон дотоод ажиллагааны горим хангасан эсэх дүгнэлт гаргаж байна.

№	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт хангасан эсэх	
		Хангасан	Хангалтгүй
1	Ажлын байр		
2	Итгэмжлэгдсэн агуулах		
3	Техникийн үзүүлэлт болон програм хангамж		
4	Байнгын гишүүний дотоод үйл ажиллагааны журам		

Дүгнэлт гаргасан:

Гишүүнчлэлийн албаны мэргэжилтэн: /

Дүгнэлтийн тайлан:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ж. ЭРДЭНЭБАТ

Хянасан:

Гишүүнчлэлийн албаны захирал

ГИШҮҮНЧЛЭЛИЙН ГЭРЭЭ (Загвар)

201.. он сар-ны өдөр

Дугаар/.....

Улаанбаатар хот

Байнгын гишүүний гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г нэг талаас “Хөдөө Аж Ахуйн Бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Ж.Эрдэнэбат нөгөө талаас ХХК (цаашид “Байнгын гишүүн” гэх)-ийг төлөөлж гүйцэтгэх захирал албан тушаалтай овогтой нар (хамтад нь “Талууд” гэх) Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам, Хөдөө аж ахуйн биржийн Гишүүнчлэлийн журам болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг үндэслэн дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож, байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ Гэрээгээр Байнгын гишүүн нь Хөдөө аж ахуйн биржийн Гишүүнчлэлийн журам (цаашид “Гишүүнчлэлийн журам” гэх)-ын-т заасан эрхийн хүрээнд Биржээс зөвшөөрсөн үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой Бирж болон Байнгын гишүүний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль болон Биржээс баталсан дүрэм журмаар зохицуулна.

ХОЁР. БАЙНГЫН ГИШҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Байнгын гишүүн гэж “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-ын 4.5.1-т заасан хуулийн этгээдийг ойлгоно.
- 2.2. Байнгын гишүүн нь Биржээс олгосон зөвшөөрөл болон энэ Гэрээний хүрээнд дараах эрхийг эдэлнэ.
 - 2.2.1. Гишүүнчлэлийн;
 - 2.2.2. Арилжааны;
 - 2.2.3. Клирингийн;
 - 2.2.4. Зах зээл үүсгэх.
- 2.3. Гэрээний 2.2-т заасан эрхийн хүрээнд Байнгын гишүүний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төрөл, чиглэл нь Гишүүнчлэлийн журамд зааснаар тодорхойлогдоно.
- 2.4. Байнгын гишүүн үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан бичиг баримтыг үйлдэж хадгална:
 - 2.4.1. Зуучлалын гэрээ;
 - 2.4.2. Данс нээх маягт;
 - 2.4.3. Захиалгын маягт;
 - 2.4.4. Бараа, түүхий эд хүлээлцэх баримт;
 - 2.4.5. Худалдах, худалдан авах гэрээний төлбөр тооцоо гүйцэтгэх баримт;
 - 2.4.6. Дэнчингийн нэхэмжлэх;
 - 2.4.7. Худалдах, худалдан авах гэрээний төлбөрийн нэхэмжлэх.
- 2.5. Гэрээний 2.4.4 - 2.4.7 дахь хэсгүүдэд заасан баримт бичиг нь Клирингийн эрхгүй гишүүнд хамаарахгүй болно.
- 2.6. Байнгын гишүүн нь Зуучлалын гэрээг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзвэл Иргэний хуульд заасны дагуу өөрийн харилцагчийг Биржийн өмнө итгэмжлэлээр төлөөлнө.

ГУРАВ. ХУГАЦАА

- 3.1. Гэрээг Талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулах бөгөөд Байнгын гишүүн нь Гэрээний 4 дүгээр бүлэгт заасан элсэлтийн болон жилийн хураамжийг төлснөөр хүчин төгөлдөр болно.
- 3.2. Гэрээний хугацаа оны ... -р сарын-ний өдрөөс оны -р сарын-ны өдөр хүртэл __ жилийн хугацаатай байгуулав.
- 3.3. Байнгын гишүүн нь Гэрээний 2.2.3-т заасан эрхийг __ сарын хугацаанд хэрэгжүүлэх ба хугацаа дууссаны дараа уг эрхийг хэрэгжүүлэх хугацааг Бирж сунгаж болно.
- 3.4. Гэрээний хугацаа дуусахаас 15 хоногийн өмнө Байнгын гишүүн нь Гэрээг сунгах тухай хүсэлтийг Биржид бичгээр гаргана. Уг хүсэлтийг үндэслэн Бирж Гэрээг сунгах асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.5. Гэрээний 3.4-т заасан хүсэлтэд Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журмын 4.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаага нотолсон баримтыг хавсаргаж ирүүлнэ.
- 3.6. Гэрээний 3.3-т заасан хугацааг сунгах эсэх асуудлыг Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэнэ.
- 3.7. Байнгын гишүүн Гэрээ дуусгавар болох өдрөөс ажлын 15 хоногийн өмнө гэрээ сунгах хүсэлт гаргаагүй, гаргасан боловч Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журмын 4.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангахгүй гэж Бирж үзсэн эсхүл гишүүнчлэлийн жилийн хураамж төлөөгүй тохиолдлуудад Бирж Гэрээг сунгахгүй.
- 3.8. Гэрээ сунгагдаагүй нь Байнгын гишүүн шалгуур үзүүлэлтийг хангаж, төлбөрийг төлсний дараа Биржид дахин хүсэлт гаргахад саад болохгүй.

ДӨРӨВ. ГИШҮҮНЧЛЭЛИЙН ТӨЛБӨР

- 4.1. Байнгын гишүүн нь Биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс тогтоосон хэмжээний дагуу дараах шимтгэл, хураамжийг төлнө. Үүнд:
 - 4.1.1. Байнгын гишүүний элсэлтийн хураамж;
 - 4.1.2. Байнгын гишүүний жилийн хураамж;
 - 4.1.3. Арилжааны шимтгэл;
 - 4.1.4. Клирингийн шимтгэл;
 - 4.1.5. Төлбөр тооцооны шимтгэл;
 - 4.1.6. Биржээс тогтоосон бусад.
- 4.2. Гэрээний 4.1.4, 4.1.5 дахь хэсэгт заасан шимтгэл нь Клирингийн эрхтэй гишүүнд хамаарахгүй болно.
- 4.3. Шинээр элссэн Байнгын гишүүн нь Биржид элсэлтийн болон жилийн хураамжийг төлнө.
- 4.4. Байнгын гишүүний элсэлтийн болон жилийн хураамжийг Биржийн заасан банкны дансанд Биржээс нэхэмжлэх хүргүүлснээс хойш 5 хоногийн дотор төлнө. Төлбөрийг уг хугацаанд төлөөгүй эсхүл төлөхөөс татгалзсан тохиолдолд Байнгын гишүүний эрх үүсэхгүй ба энэхүү Гэрээг байгуулагдаагүйд тооцно.
- 4.5. Шинээр элсэж буй Байнгын гишүүн нь элсэлтийн хураамжийг нэг удаа төлөх ба цаашид Гишүүнчлэлийн жилийн хураамжийг төлнө.
- 4.6. Биржээс хураамжийн төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд Байнгын гишүүнд мэдэгдэх ба уг өөрчлөлт нь Гэрээний хугацаанд үйлчлэхгүй. Гэрээний хугацаа дууссаны дараа Гэрээ сунгагдах тохиолдолд хураамжийн төлбөрийг өөрчлөгдсөн хэмжээгээр тооцно.
- 4.7. Бирж Байнгын гишүүний эрхийг түдгэлзүүлсэн, Гэрээг цуцалсан нь урьдчилан төлсөн шимтгэл, хураамжийн төлбөрийг буцаан олгох үндэслэл болохгүй.
- 4.8. Байнгын гишүүний харилцагчаас авах зуучлалын шимтгэл нь нийт хэлцлийн дүнгийн __ хувьтай тэнцүү байна.

ТАВ. БАЙНГЫН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Байнгын гишүүн нь хууль тогтоомжид зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 5.1.1. Харилцагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр Биржийн арилжаанд саадгүй оролцох;
 - 5.1.2. Байнгын гишүүний эрх, түүний хүрээнд явуулж буй өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Биржээс тодруулга, мэдээлэл авах,
 - 5.1.3. Биржид санал, хүсэлт гаргах;
 - 5.1.4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай саналыг Биржид гаргах;
 - 5.1.5. Биржээс баталсан өөрийн холбогдох дүрэм, журамтай танилцах.
- 5.2. Байнгын гишүүн нь хууль тогтоомжид зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 5.2.1. Харилцагчийн болон өөрийн оруулсан аливаа захиалгын үнэн зөв байдлыг хангаж ажиллах;
 - 5.2.2. Харилцагчид биржийн арилжаатай холбоотой эрсдэл, хүлээж болзошгүй алдагдлын талаарх тайлбар өгөх, анхааруулах, худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах;
 - 5.2.3. Харилцагчийн арилжааны данс нээх, захиалгыг арилжааны програмд шивж оруулах, захиалга өөрчлөх бүр харгалзах маягтад заасан мэдээллийг Биржийн програмд үнэн зөвөөр бүртгэх;
 - 5.2.4. Биржийн арилжаатай холбоотой олж авсан харилцагчийн дансны болон холбогдох санхүүгийн мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
 - 5.2.5. Байнгын гишүүний хаяг, байршил тодорхой байх ба шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл болон Байнгын гишүүн компани өөрчлөн зохион байгуулагдах тохиолдолд өөрчлөлтийг ажлын 1 өдрийн дотор Биржийн гишүүнчлэлийн албад бичгээр мэдэгдэж байх;
 - 5.2.6. Гишүүнчлэлийн журамд заасны дагуу төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын үед хуулиар хориглоогүй шаардлагатай баримт, холбогдох мэдээ мэдээллийг шалгалтын бүрэлдэхүүнд гаргаж өгөх, Биржид хүргүүлэх;
 - 5.2.7. Хяналт, шалгалтын дүгнэлтээр зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчил арилгах үүрэг даалгаврыг биелүүлэх;
 - 5.2.8. Биржээс зохион байгуулж байгаа аливаа арга хэмжээ болон сургалтад идэвхтэй оролцох;
 - 5.2.9. Холбогдох хуульд заасны дагуу бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсхүл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх;
 - 5.2.10. Биржээс суулгаж өгсөн програм хангамжийн ашиглалт, түүний аюулгүй байдал, нэвтрэх нэр, нууц үгийн нууцлалыг Байнгын гишүүн бүрэн хариуцах.

ЗУРГАА. БИРЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1. Бирж хууль тогтоомж болон Биржийн дотоод дүрэм журамд зааснаас гадна дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 6.1.1. Байнгын гишүүний эрхтэй холбогдсон үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;
 - 6.1.2. Байнгын гишүүн энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд Гэрээний 8 дугаар бүлэгт заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
 - 6.1.3. Байнгын гишүүний холбогдон ажилладаг цахим системийн үйл ажиллагааны горимд шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт хийх;
 - 6.1.4. Гишүүнчлэлийн журам болон Гэрээний 8 дугаар бүлэгт заасны дагуу Байнгын гишүүнд хариуцлага тооцох;

- 6.1.5. Байнгын гишүүний харилцагч болон гуравдагч этгээдээс Байнгын гишүүний үйл ажиллагаатай холбоотой санал, хүсэлт, гомдол ирүүлсэн тохиолдолд асуудлыг шийдвэрлэх;
- 6.1.6. Гэрээнд заасан үндэслэл, журмын дагуу Гэрээг цуцлах.
- 6.2. Бирж хууль тогтоомж болон Биржийн дотоод дүрэм журамд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ. Үүнд:
 - 6.2.1. Энэ гэрээний 2.2-т заасан эрхийг олгох;
 - 6.2.2. Гишүүнчлэлийн журмын 4.2-т заасан эрхийг олгох;
 - 6.2.3. Арилжаа зохион байгуулах, Байнгын гишүүний арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэх;
 - 6.2.4. Биржийн зүгээс Байнгын гишүүн өөрийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай програм хангамж суулгаж өгөх;
 - 6.2.5. Байнгын гишүүнээс Биржийн арилжаатай холбоотой мэдээ, мэдээллийг гаргуулах;
 - 6.2.6. Байнгын гишүүний санхүүгийн тайлан, бизнес төлөвлөгөө, хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах;
 - 6.2.7. Биржийн үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр, холбогдох хууль зүйн актын өөрчлөлт, мэдээллийг Байнгын гишүүнд мэдээлэх;
 - 6.2.8. Байнгын гишүүнд холбогдох арилжааны лавлагаа, түүхий эдийг экспортод гаргах барааны тодорхойлолт, хэлцлийн жагсаалт, дансны хуулгыг Байнгын гишүүний хүсэлтийн дагуу гаргаж өгөх;
 - 6.2.9. Байнгын гишүүнтэй холбогдох үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийг хууль болон холбогдох дүрэм, журмын дагуу тооцож нэхэмжлэх.

ДОЛОО. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- 7.1. Хууль тогтоомжид зааснаас гадна Бирж дараах тохиолдлуудад Гэрээг өөрийн санаачилгаар цуцалж, дуусгавар болгоно.
 - 7.1.1. Гэрээний хугацаа дууссан ба Байнгын гишүүн Гэрээг сунгах талаар хүсэлт ирүүлээгүй;
 - 7.1.2. Биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасан гишүүн оролцогчийн эрхийг цуцлах үндэслэл бүрдсэн;
 - 7.1.3. Байнгын гишүүн хууль тогтоомж болон Гэрээг зөрчсөн үйлдэл гаргасан;
 - 7.1.4. Биржээс тогтоосон журмын дагуу явуулсан хяналт, шалгалтын явцад Байнгын гишүүн хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн нь илэрсэн;
 - 7.1.5. Байнгын гишүүний хураамж болон шимтгэлийн төлбөрийг хугацаандаа бүрэн төлөөгүй;
 - 7.1.6. Санхүүгийн зохицуулах хорооноос Байнгын гишүүнд олгосон тусгай зөвшөөрөл түдгэлзсэн, хугацаа дууссан, цуцлагдсан.
- 7.2. Бирж нь Гэрээний 7.1-т заасны дагуу Гэрээг цуцалсан, дуусгавар болгосны улмаас Байнгын гишүүний харилцагчид учирсан аливаа хариуцлага болон хохирлыг хүлээхгүй болно.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1. Байнгын гишүүн хууль тогтоомж, Биржээс баталсан дүрэм, журмууд болон Гэрээний заалтыг зөрчсөн нь Биржийн үйл ажиллагаа, нэр хүнд, арилжаа, арилжаанд оролцогч, Байнгын гишүүний харилцагчдад сөргөөр нөлөөлсөн эсхүл нөлөөлөхөөр үндэслэлтэй гэж Биржийн зүгээс үзсэн тохиолдолд зөрчлийн хэмжээнээс шалтгаалж дараах арга хэмжээг Бирж сонгож шууд эсхүл шат дараалан авна.
 - 8.1.1. Зөрчлийг арилгах талаарх шаардлагыг Байнгын гишүүнд хүргүүлэх замаар хоёр хүртэлх удаа албан бичгээр сануулга өгөх;
 - 8.1.2. Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх;
 - 8.1.3. Гишүүнчлэлийн журмын 4.2-т заасан эрхийг бүхэлд нь болон хэсэгчлэн түдгэлзүүлэх;
 - 8.1.4. Гишүүнчлэлийн журмын 4.2-т заасан эрхийг хэсэгчлэн цуцлах;
 - 8.1.5. Гэрээг цуцлах.

- 8.2. Бирж нь Гэрээний 8.1.3-8.1.5-т заасны дагуу Гэрээг түдгэлзүүлсэн болон цуцалсны улмаас Байнгын гишүүний харилцагчид учирсан аливаа хариуцлага болон хохирлыг хүлээхгүй болно.

ЕС. ХЭРЭГЛЭГДЭХ ХУУЛЬ БА МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 9.1. Энэхүү Гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан бөгөөд талуудын хооронд гарсан аливаа маргааныг Монгол Улсын хууль, тогтоомжоор хянан шийдвэрлэгдэнэ.
- 9.2. Гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргаан, санал зөрөлдөөнийг Талууд ижил тооны төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр уулзалт хийж, эвлэрлийн журмаар шийдвэрлэнэ. Уулзалтын үр дүнд Талууд эвлэрэлд хүрээгүй бол маргааныг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРАВ. БУСАД

- 10.1. Гэрээг Монгол хэл дээр, бичгээр хоёр хувь үйлдсэн бөгөөд Талууд тус бүр нэг нэг хувийг хадгална.
- 10.2. Гэрээний хавсралт, аливаа нэмэлт өөрчлөлтүүд нь Гэрээний салшгүй нэг хэсэг байна.
- 10.3. Энэхүү Гэрээний эрх үүрэг, өр төлбөр, шаардах эрхийг Гэрээний аль нэг тал аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Энэ журмыг зөрчиж эрх үүрэг, өр төлбөр, шаардах эрх шилжүүлсэн аливаа шийдвэр, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

БИРЖИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
Ж.Эрдэнэбат

/_____/

БАЙНГЫН ГИШҮҮНИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“.....”ХХК-ийн
Гүйцэтгэх захирал
.....

/_____/

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
8 дугаар хороо, Бээжингийн гудамж,
GB плаза

Утас: 976-7014-8779
Факс: 976-7014-8779
Цахим шуудан: info@mce.mn

Утас:
Факс:
Цахим шуудан: